



**НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар A/10

Улаанбаатар хот

Илүү цаг олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/132 дугаар захирамж, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотод өвлийн спортыг хөгжүүлэх, өвлийн спортын төрлүүдийг сурталчлан таниулах зорилгоор иргэдийн дунд “Нийслэлийн өвлийн спортын наадам”-ын арга хэмжээнд 2025 оны 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд “Скай ресорт” цанын баазад зохион байгуулахад ажилласан албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлсийг олгосугай.

2.Албан хаагчдад олгох илүү цагийн нэмэгдэл хөлсийг зохих журмын дагуу тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (М.Цогзолмаа)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.САРАНЦЭЦЭГ



